

**“ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ПРОТОКОЛ**

Хуралдсан огноо: 2021 оны 4 сарын 27

Хуралдсан хэлбэр: Цахимаар (zoom)

Хурлын цаг: 10:00 – 11:00

Хуралд оролцсон:

1. Цэгмид Оюунтуяа /5.0% хувьцаа эзэмшигч /
2. He Shanjun /5.0% хувьцаа эзэмшигч /
3. Yeh Mongomer /89.6% хувьцаа эзэмшигч /

Хуралд байлцсан:

1. He Jingwen /Гүйцэтгэх захирал, Хурлын дарга /
2. Shih Pei Chin /ТУЗ-н гишүүн/
3. Tseng Tzu-Hsiang /ТУЗ-н гишүүн/
4. Qi Wei /ТУЗ-н гишүүн/
5. Ж. Сүхнаран /ТУЗ-н гишүүн/
6. Т. Баярмаа / ТУЗ-н нарийн бичгийн дарга/

Тооллогын комисс:

1. Г. Ариунчимэг
2. Г. Номинтөгөлдөр

Монгол улсын хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын 10 аас 25 ны өдрийг дуустал зарласан бүх нийтийн бэлэн байдал буюу хатуу хөл хориог дахин 5 дугаар сарын 9 ний өдрийг дуустал сунгасантай холбоотой ТУЗ-ийн тогтоолд заасан хуралдах газарт хурлыг зохион байгуулах боломжгүй тул “Зүүм”-р хуралдах болсон тухай ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Баярмаа ярих. Тооллогын комиссын дарга Г. Ариунчимэг хурлын ирцийг мэдээлэв. Нийт 99.6 хувь буюу нийт 71,877 ширхэг энгийн хувьцааг эзэмшигч хуралд оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөр эхлүүлэв. Гүйцэтгэх захирал He Jingwen уламжлал ёсоор орчуулга хийхээр болов.

Хурлын дарга He Jingwen хурлыг нээж хүрэлцэн ирсэн хуралд оролцогчдод мэнд дэвшүүлэв. Хурлын дэг, хэлэлцэх асуудал танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. 2020 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2020 оны ногдол ашгийн талаарх шийдвэрийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох
4. 2021 оны ТУЗ-ийн төсвийг батлах

1. 2020 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах:

- ❖ 2020 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэхийн зэрэгцээ өнгөрсөн жилийн тайлангуудын талаар ч танилцуулав. Өнгөрсөн оны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангууд гарч холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлж баталгаажуулжээ. Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Шинэ их тэрбум аудит” ХХК -ийг сонгон Компанийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан ба тус дүгнэлтийг төлөөлөн удирдах зөвлөл хүлээн зовшоорсон талаар хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчид зовшооров. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ихэнх нь гадаадын иргэд тул дэлхий даяар цар тахал дэгдэж, хөл хорио тогтоосны улмаас ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл хэрэгт саадтай байсантай холбоотой төлөвлөгөөний дагуу ажиллах боломж бүрдээгүй хэмээн үзсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчид батлахыг бүгд зовшооров.

2. 2020 оны ногдол ашгийн талаарх шийдвэрийг танилцуулах:

- ❖ Компанийн тухай хуулийн 46.8, Компанийн дүрмийн 4.6 дэх хэсэгт заасан шалгуурыг хангахгүй байгаа буюу тайлан алдагдалтай байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолтой хувьцаа эзэмшигчид танилцав.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох

- ❖ ТУЗ-ийн 3 гишүүн гишүүн чөлөөлөгдөх хүсэлтээ илэрхийлж 3 сарын 16 ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүний шалгуурыг хангасан Ж.Сүхнаран, Tseng Tzu-Hsiang, Wei Qi нарын 3 гишүүнийг түр томилсон билээ. Компанийн тухай хуульд зааснаар куммулятив аргаар сонгосон бол ТУЗ-ын бүх гишүүдийг чөлөөлж дахин сонгодог. Энэхүү үйл явдалтай холбоотой ТУЗ-ийн тогтоол, нэр дэвшүүлэх хорооны шийдвэртэй бүгд танилцаж хэлэлцээд ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар дахин сонгохыг 100 хувь дэмжлээ.

- Yeh Montgomer (хараат гишүүн)
- He Shanjun (хараат гишүүн)
- Tseng Tzu-Hsiang (хараат гишүүн)
- Lin Yu Fei (хараат гишүүн)
- Qi Wei (хараат гишүүн)
- Shih Pei Chih (хараат гишүүн)
- Tsai Chin Kun (хараат бус гишүүн)
- Ku Cheng Chuan (хараат бус гишүүн)
- Жигжид овогтой Сүхнаран (хараат бус гишүүн)

Компанийн дүрмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно гэсэн байдаг. Манай компанийн дүрмийн 7.40 дэх хэсэгт ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 3 жилийн хугацаатай сонгож болно гэж заасан байдаг талаар ТУЗ-ын нарийн бичгийн дарга дурдав. Хувьцаа эзэмшигчид бүрэн эрхийн хугацааг 3 жилээр тогтоохыг санал нэгтгэй зовшооров.

4. 2021 оны ТУЗ-ийн төсвийг батлах

- ❖ 3 сарын 16 ны өдрийн ТУЗ-н хурлаар хэлэлцсэн 2021 оны ТУЗ-ийн төсөв 5,500,000 байхаар хэлэлцэснийг хувьцаа эзэмшигчид санал нэгтгэй зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь:

- 2020 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүтгэлтийг батлахыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид 100.0 хувь зөвшөөрөв.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдалаар шинээр томилох, мөн тэдний бүрэн эрхийн хугацааг Компанийн дүрэмд заасны дагуу 3 жилээр тогтоохыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид 100.0 хувь зөвшөөрөв.

- Yeh Montgomer (хараат гишүүн)
- He Shanjun (хараат гишүүн)
- Tseng Tzu-Hsiang (хараат гишүүн)
- Lin Yu Fei (хараат гишүүн)
- Qi Wei (хараат гишүүн)
- Shih Pei Chih (хараат гишүүн)
- Tsai Chin Kun (хараат бус гишүүн)
- Ku Cheng Chuan (хараат бус гишүүн)
- Жигжид овогтой Сүхнаран (хараат бус гишүүн)

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн 2021 оны ТУЗ-ийн төсвийг 5,500,000 төгрөг байхаар батлахыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид 100.0 хувь зөвшөөрөв.

Ийнхүү хэлэлцэх асуудлууд дуусч энэхүү хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар тогтоол гаргахаар тогтож, тогтоолын төсөл бүрийг Гүйцэтгэх захирал He Jingwen нийт гишүүдэд орчуулж өгч, тэдгээрийг санал нэгтгэйгээр батлав. Тооллогын комиссын тогтоол мөн танилцуулагдав.


Хурлын гэмдэглэл хөтөлсөн:

Т. Баярмаа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

БАТАЛСАН.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА:



/HE JINGWEN /